



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2024 оны 11 сарын 19 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн
дүрэм, журмыг шинэчлэн батлах тухай**

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 35 дугаар зүйлийн 35.15, 35.16 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг нэгдүгээр хавсралтаар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогч, даатгуулагчийн төлөөллийг нээлттэй сонгон шалгаруулах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд олгох урамшууллын хэмжээг эрх бүхий байгууллагаас тогтоосон сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр сар бүр тооцож, улирал тутам олгож байхаар тогтоосугай.

3.Энэ дүрмийг мөрдөж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга (Л.Энх-Амгалан)-д даалгасугай.

4.Энэ тогтоол баталсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2018 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм шинэчлэн батлах тухай” 19 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Л.ЭНХНАСАН

Монгол Улсын Их хурлын Нийгмийн бодлогын
байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 19-ний
өдрийн 01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмийн зорилго нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл /цаашид “Үндэсний зөвлөл” гэх/-ийн үйл ажиллагаа, зарчим, Үндэсний зөвлөлийн дарга, гишүүдийн бүрэн эрх, ажлын албаны зохион байгуулалтын бүтцийг тодорхойлоход оршино.

1.2.Үндэсний зөвлөл Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллана.

1.3.Үндэсний зөвлөл нийгмийн даатгалын үйл ажиллагаанд хууль дээдлэх, хараат бус, хариуцлагатай, нээлттэй, ил тод байдал, даатгагч, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, төр, хуулийн этгээд, иргэний тэгш оролцоог хангах, асуудлыг хамтын удирдлагаар хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг баримтална.

1.4.Үндэсний зөвлөлөөс батлан гаргасан тогтоол, дүрэм, журам, аргачлал, зөвлөмж, удирдамжийг нийгмийн даатгалын байгууллага болон нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талууд хэрэгжүүлэх үүрэгтэй.

1.5.Үндэсний зөвлөл тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.6.Үндэсний зөвлөл үйл ажиллагааны зардлын төсөвтэй байна. Үндэсний зөвлөлийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Хоёр.Үндэсний зөвлөлийн хуралдаан

2.1.Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

2.2.Үндэсний зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа гишүүдийн гуравны хоёроос доошгүйн ирцтэйгээр хуралдах бөгөөд хуралдааныг Үндэсний зөвлөлийн дарга удирдана. Шаардлагатай тохиолдолд Үндэсний зөвлөлийн дарга, гишүүдийн олонхын саналаар ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

2.3.Онцгой нөхцөлд Үндэсний зөвлөлийн хуралдааныг цахимаар хийж болно.

2.4.Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос дээш хувийн саналаар шийдвэрлэнэ.

2.5.Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу төрийн захиргааны төв

байгууллага, холбогдох бусад байгууллагаас санал авахаар заасан бол эдгээр байгууллагаас санал ирүүлсний дараа тухайн асуудлыг хуралдаанаар хэлэлцэнэ.

2.6.Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35.17-д заасан мэргэжлийн хороо судалгаа тооцоолол хийж, эрсдэлийг үнэлэн, дүгнэлт, саналаа боловсруулан асуудал тус бүрээр зөвлөмж бэлтгэж, хуралдаан эхлэхээс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө гишүүдэд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.7.Ажлын алба Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг хүлээн авч хянаад хуралдааны тов, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, холбогдох баримт бичгийг хуралдаан зохион байгуулахаас ажлын 5 өдрийн өмнө Үндэсний зөвлөлийн гишүүдэд хүргүүлж, холбогдох байгууллагад мэдээлнэ.

2.8.Үндэсний зөвлөлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой болон нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргана. Тогтоолд Үндэсний зөвлөлийн дарга гарын үсэг зурж, баталгаажуулна.

2.9.Ажлын алба хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг дэс дарааллын дагуу нэг бүрчлэн хуралдааны тэмдэглэлд тусгаж, хянах бөгөөд эрх бүхий албан тушаалтан болон ажлын албаны дарга уг хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, гарын үсэг зурна.

2.10.Хуралдааны тэмдэглэлтэй Үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүд танилцан гарын үсэг зурж, баталгаажуулна.

2.11.Үндэсний зөвлөлийн хуралдааны дэгийг Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, батална.

Гурав.Үндэсний зөвлөлийн эрх, үүрэг

3.1.Үндэсний зөвлөл Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 35 дугаар зүйлийн 35.9 дэх хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна дараах эрх эдэлнэ:

3.1.1.Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлэх;

3.1.2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмж, төлбөр, зардлын төлбөрийн хэмжээг өөрчлөх, сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд оруулах талаар нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас боловсруулсан тооцоо судалгаа, саналыг хянаж, санал, дүгнэлт гаргах;

3.1.3.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас Үндэсний зөвлөлийн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг, мэдээлэл, судалгаа авах;

3.1.4.Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлагад хийх хяналт шалгалтад мэргэжлийн хороо, олон нийтийн хяналтын зөвлөлийг оролцуулах;

3.1.5.Ажлын алба, мэргэжлийн хороо, олон нийтийн хяналтын зөвлөлийг удирдлага, чиг үүргээр хангаж ажиллах.

3.2.Үндэсний зөвлөл дараах үүргийг гүйцэтгэнэ:

3.2.1.Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт болон нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавих ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх;

3.2.2.Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, санхүүгийн асуудлаар нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тайлан, мэдээллийг хэлэлцэж, санал, дүгнэлт гаргах, холбогдох арга хэмжээ авах;

3.2.3.Нийгмийн даатгалын сангийн хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, нийгмийн даатгалын сангийн жилийн төсвийн гүйцэтгэл, аудит хийсэн санхүүгийн тайланг дараа оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор хянан хэлэлцэх;

3.2.4.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын үнэт цаас, Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг тогтооход санал өгөх, арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээг хуульд заасан аргачлалаар тооцож, батлах;

3.2.5.Мөнгөжүүлсэн орлогыг хассан даатгуулагчийн нэрийн дансны шимтгэлийн орлогод жил бүр тооцох хүүгийн хэмжээг тогтоох;

3.2.6.Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нийгмийн даатгалын асуудлаар ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг хуульд заасан хугацаанд судлан шийдвэрлэх;

3.2.7.Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд Засгийн газар, ажил олгогч, даатгуулагч, иргэд, олон нийтийн байгууллагын идэвхтэй оролцоог хангуулах;

3.2.8.“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого” болон бусад бодлогод нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилтууд, Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого /2015-2030/-ын хэрэгжилтэд хяналт тавьж, шаардагдах арга хэмжээ авах;

3.2.9.Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Дөрөв.Үндэсний зөвлөлийн дарга, гишүүдийн эрх, үүрэг

4.1.Үндэсний зөвлөлийн дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1.Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, жилийн тайланд үнэлэлт дүгнэлт өгч, үйл ажиллагааны гүйцэтгэлийг Улсын Их Хуралд тайлагнах;

4.1.2. Үндэсний зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг боловсруулж, гишүүдийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих;

4.1.3. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон бусад холбогдох асуудлаар гишүүдээс гаргасан саналыг судлан шийдвэр гаргах;

4.1.4. Үндэсний зөвлөлийн хуралдааны тов болон хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тогтоох;

4.1.5. Төрийн болон олон нийтийн албан ёсны үйл ажиллагаанд Үндэсний зөвлөлийг төлөөлөн оролцох.

4.2. Үндэсний зөвлөлийн гишүүд дараах эрх, үүрэгтэй:

4.2.1. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд нийгмийн даатгалын хууль тогтоомж, энэ дүрэм, холбогдох бусад эрх зүйн баримт бичгийг мөрдлөг болгон ажиллах;

4.2.2. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны талаар үзэл бодол, саналаа нээлттэй, ил тод илэрхийлэх;

4.2.3. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, шаардлагатай тохиолдолд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасны дагуу ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдлийг Үндэсний зөвлөлд урьдчилан мэдэгдсэнээр тухайн асуудалтай холбоотой Үндэсний зөвлөлийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд санал өгөх эрхгүйгээр оролцох;

4.2.4. Үндэсний зөвлөлийн хуралдаанд тухай бүр оролцох;

4.2.5. Үндэсний зөвлөлийн хуралдаанд холбогдох асуудлаар санал тавьж хэлэлцүүлэх;

4.2.6. Шийдвэр гаргахад шаардлагатай баримт бичиг, мэдээ, мэдээллийг Үндэсний зөвлөл болон нийгмийн даатгалын байгууллагаас гаргуулан авах, хүний хувийн мэдээлэл болон байгууллагын нууцыг хадгалах.

Тав. Үндэсний зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт

5.1. Үндэсний зөвлөлийн зохион байгуулалтын бүтцэд ажлын алба, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35.17-д заасан мэргэжлийн хороо, олон нийтийн хяналтын зөвлөл багтана.

5.2. Үндэсний зөвлөл нийгмийн даатгалын хууль тогтоомжоор хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэх, нийгмийн даатгалын асуудлаар шийдвэр гаргахад мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, судалгаа, дүгнэлт гаргуулах, гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор ажлын албыг ажиллуулна.

5.3. Ажлын албаны бүтэц, ажиллах журмыг Үндэсний зөвлөл батална.

5.4.Ажлын албаны даргыг Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, Үндэсний зөвлөлийн дарга томилж, чөлөөлнө. Ажлын албаны ажилтнуудыг ажлын албаны дарга томилж, чөлөөлнө.

5.5.Ажлын албаны дарга нь Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга байна.

5.6.Ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал нь төрийн захиргааны албан тушаалд хамаарах бөгөөд цалингийн сүлжээ, зэрэг дэвийг Улсын Их Хурлаас томилогддог байгууллагын ажлын албатай дүйцүүлэн тогтооно.

5.7.Үндэсний зөвлөл дэргэдээ нийгмийн даатгалын тогтолцоо, хууль тогтоомж, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, сангийн орлогыг бүрдүүлэх, зарцуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэр гаргахад шаардлагатай судалгаа, эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий эрсдэлийн удирдлага, актуар тооцоолол хийх, хөрөнгө оруулалт, аудитын хараат бус мэргэжлийн хороог ажиллуулна.

5.8.Мэргэжлийн хорооны гишүүний нээлттэй сонгон шалгаруулалт явуулах болон хорооны үйл ажиллагааны чиглэл, бүтэц, зохион байгуулалт, гишүүдэд олгох урамшууллын хэмжээг зохицуулсан журмыг Үндэсний зөвлөл батална.

5.9.Мэргэжлийн хороо нь орон тооны бус гишүүдээс бүрдэх бөгөөд Үндэсний зөвлөлөөс баталсан журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

5.10.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд оруулах үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий олон нийтийн хяналтын зөвлөлийг Үндэсний зөвлөлийн ажлын албаны дэргэд ажиллуулна.

5.11.Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүдийг Үндэсний зөвлөл нээлттэй сонгон шалгаруулан томилж, чөлөөлөх бөгөөд хууль дээдлэн, аливаа нөлөөнд автахгүйгээр хараат бус, бие даасан, хөндлөнгийн хяналт тавьж ажиллах үүрэгтэй.

5.12.Олон нийтийн хяналтын зөвлөл нь хөрөнгө оруулалтын мэргэжлийн хороо болон төрийн, төрийн бус байгууллага, даатгуулагчийн төлөөлөл бүхий орон тооны бус 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналд үндэслэн Үндэсний зөвлөлийн баталсан дүрмийг мөрдөж ажиллана.

Зургаа.Хариуцлага

6.1.Энэ дүрмийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

Монгол Улсын Их хурлын Нийгмийн бодлогын
байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 19-ний
өдрийн 0.1 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙГ НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

3761 9023051390 9087184

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 35 дугаар зүйлийн 35.3, 35.4 дэх хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажил олгогч болон даатгуулагчийн төлөөллийн байгууллагын гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулах үйл ажиллагаа /цаашид “гишүүний сонгон шалгаруулалт” гэх/-г зохицуулна.

Хоёр.Гишүүний сонгон шалгаруулалтад хамрагдах талууд

2.1.Гишүүний сонгон шалгаруулалтад Үндэсний зөвлөлийн дараах талууд хамрагдана:

2.1.1.Ажил олгогчийг төлөөлж ажил олгогчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллага;

2.1.2.Даатгуулагчийг төлөөлж даатгуулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан үйлдвэрчний эвлэл.

Гурав.Гишүүний сонгон шалгаруулалтын тов, нэр дэвшигчдэд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг

3.1.Энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасан ажил олгогч болон даатгуулагчийн төлөөллийн байгууллага дотооддоо гишүүний нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

3.2.Гишүүний нээлттэй сонгон шалгаруулалтыг тухайн байгууллагын гүйцэтгэх удирдлага хариуцан гүйцэтгэнэ.

3.3.Гүйцэтгэх удирдлага нь сонгон шалгаруулалтын тов, үргэлжлэх хугацааг тогтоож, зарыг 14-өөс доошгүй хоногийн өмнө тухайн байгууллагын цахим хуудас болон 5-аас доошгүй хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүртээмжтэй байдлаар олон нийтэд мэдээлнэ.

3.4.Сонгон шалгаруулалтад оролцогчид дараах шаардлагыг хангасан байна:

3.4.1.Монгол Улсын иргэн байх;

3.4.2.Хууль эрх зүй, санхүү, эдийн засаг, удирдахуйн ухаан, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр бакалавр ба түүнээс дээш боловсрол эзэмшсэн, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх;

3.4.3.Хугацаа хэтэрсэн нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй байх /бүх төрлийн тэтгэвэр авагч хамаарахгүй/;

3.4.4.Хувь хүний ёс зүй, нэр хүнд нь Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх;

3.4.5.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалттай зөрчилдөхгүй байх;

3.4.6.Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх.

3.5.Сонгон шалгаруулалтад оролцогчоос дараах баримт бичгийг цаасаар, эсхүл цахимаар хүлээн авна. Үүнд:

3.5.1.Төрийн албан хаагчийн анкет;

3.5.2.Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичгийн эх хувийг нотариатаар гэрчлүүлсэн хувь /гадаадад их, дээд сургууль төгссөн бол баталгаат орчуулгын хамт/;

3.5.3.Үндэсний зөвлөлийн гишүүнээр ажиллах зорилго, хийх ажил, өөрийн мэдлэг, ур чадвараа илэрхийлсэн хүсэлт;

3.5.4.Иргэний үнэмлэхийн хуулбар;

3.5.5.Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа /хувь хүн өөрийн болон төлөөлсөн байгууллагын/;

3.5.6.Цээж зураг /4х3 хэмжээтэй 2 хувь/.

Дөрөв.Гишүүний сонгон шалгаруулалт явуулах

4.1.Гүйцэтгэх удирдлага сонгон шалгаруулалтад оролцогчдын ирүүлсэн баримт бичгийн бүрдлийг хянаж, шаардлага хангасан оролцогчдын жагсаалтыг гаргаж, тухайн байгууллага нийт төлөөллийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

4.2.Хуралдаанаар нэр дэвшигчийн сонсгол хийж, оролцогчдоос нийгмийн даатгалын үйл ажиллагаанд оролцох чиглэлээр ажиллах хүсэл сонирхол, чадвар, туршлага, ажил олгогч болон даатгуулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чадварыг шалгуур болгон нэр дэвшигчдийг сонгож, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, энэ журмын 3.5-д заасан баримт бичиг болон хуралдааны шийдвэрийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

Тав.Бусад зүйл

5.1.Энэхүү журмаар зохицуулагдаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

---o0o---